



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 01 дүгээр сарын 25 өдөр Дугаар 10

Хэрлэн сум

Х ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 10 дугаар хуралдаан 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 17:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 93,2 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1. Сумдын спорт заалыг нээх эсэх талаар хэлэлцэх,

Мэргэжлийн хяналтын газар,

2. Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх үйл ажиллагааг хориглосон цагийн хязгаарлалтыг сунгах талаар хэлэлцэх,

Цагдаагийн газар

3. Ачаа тээврийн карго үйлчилгээний талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай хэлэлцэх

АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс

4. Албан үүргээ сайн гүйцэтгэсэн алба хаагчдийг шагнаж, урамшуулах тухай хэлэлцэх,

АЗДТГ-ын Хууль, эрхзүйн хэлтэс

5. Аймгийн Онцгой комисст иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас ирсэн санал хүсэлтийн талаар хэлэлцэх



Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д. Мөнхтуяа.

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г. Нармандах нарт:

1.1. Сумын ерөнхий боловсролын сургуулиас бусад спорт заалны үйл ажиллагааг эхлүүлэх талаар сумын Онцгой комисст зөвлөмж хүргүүлэхийг,

/  / М.Бадамсүрэн
/  / Э.Ганжигүүр

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

1.2.Аймгийн Онцгой комиссын тогтоолыг хуулбар үнэн гэсэн тэмдэг дарж олон нийтэд хүргэж байхыг,

Хоёр.АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Баяржаргал, Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг нарт:

2.1.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагааг 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 08:00 цагаас 2020 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн 08:00 цаг хүртэлх хугацаанд түр хориглох тухай аймгийн Засаг даргын захирамж боловсруулж батлуулахыг,

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Онцгой комиссын гишүүн П.Бат-Өлзий-д:

2.2.Коронавируст халдвар /COVID-19/-аас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр Аймгийн Засаг даргын зарим захирамжуудыг чиглэл тус бүрээр шинэчлэн аймгийн Засаг даргын захирамж боловсруулж батлуулахыг,

Гурав.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа, Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Мөнхтөр нарт:



3.1.Ачаа тээврийн карго үйлчилгээ эрхлэх сонирхолтой аж ахуйн нэгж байгууллагын шаардлага хангасан талаарх судалгааг гаргаж гэрээний төслийг боловсруулж аймгийн Онцгой комисс, Шуурхай штабын хуралд танилцуулж шийдвэрлүүлэхийг,

Дөрөв.АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Баяржаргал-д:

4.1.Онцгой нөхцөлд албан үүргээ сайн гүйцэтгэсэн Хэрлэн сумын 2 дугаар багийн хэсгийн байцаагч, дэслэгч Д.Батнасанг 250,000 төгрөгөөр урамшуулах тухай албан бичгийг боловсруулж аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах, мөн Хэрлэн сумын 2 дугаар багийн хэсгийн ахлагч нарыг урамшуулах тухай саналыг албан бичгээр Хэрлэн сумын Засаг даргад хүргүүлэхийг,

Тав. Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал, Онцгой комиссын гишүүн Д.Должин-д

5.1.Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөс аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Улаанбаатар хотоос Дорнод аймагт засварын багийн бүрэлдэхүүнийг нэвтрүүлэх тухай" хүсэлтийн дагуу Дорнод аймагт нэвтрэх иргэдийг тусгаарлалт,

/  / М.Бадамсүрэн
/  / Э.Ганжигүүр

ажиглалтын дэглэмийг мөрдүүлж халдвар хамгааллын журмын дагуу нэвтрүүлэхийг зөвшөөрөв,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
цагдаагийн хурандаа Т.Ганзориг-т:

5.2.Цагдаагийн газраас аймгийн Онцгой комисст танилцуулсан “Алба хаагч нарын хамгаалах малгай шийдвэрлүүлэх тухай” хүсэлтийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж хөрөнгийг шийдвэрлүүлэхийг,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа,
Гаалийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Б.Гэрэлт-Од,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа,
Хэрлэн сумын Засаг дарга, Онцгой комиссын
гишүүн О.Пүрэв-Очир,
Улаанбаатар төмөр замын Баянтүмэн тасгийн
дарга П.Түвшинжаргал,
“Дорнод гурил” ХХК-ийн захирал А.Рэнцэндорж нарт:

5.3.“Дорнод гурил” ХХК-ийн ОХУ-аас 3000тн улаанбуудай татах зөвшөөрөл хүсэх тухай албан бичгийн дагуу Зам тээврийн хөгжлийн сайд, Улсын Онцгой комисс, Хил хамгаалах ерөнхий газар зөвшөөрсөн тохиолдолд Эрэнцав хилийн боомтоор нэвтрүүлэхийг,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа-д:

5.4.Хилийн Эрэнцав боомтоор ачаа тээвэр, эрдэс баялаг, бусад бараа бүтээгдэхүүний экспорт, импортын хүрээнд ачаа тээврийг ачих, буулгах, тээвэрлэх үед хяналт шалгалт хийх удирдамж боловсруулж батлуулахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГА М.БАДАМСҮРЭН

БҮСИЙН ТӨВ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН
ГАЗРЫН АХМАД Э.ГАНЖИГУҮР

